

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН
ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч /цаашид “ҮМҮЧЭТХЭАЭ” гэх/-ийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын хэрэгжилт, санхүү, төлбөрийн чадвар, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2. Энэ журамд заасан хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамжийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга батална.

1.3. Монголбанк болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийхэд энэ журмыг баримталж болно.

1.4. Хороо дор дурдсан этгээдийн үйл ажиллагаанд энэ журмын дагуу зайнаас болон газар дээрх хяналтыг тавина. Үүнд:

1.4.1. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх этгээд;

1.4.2. Үнэт металл, үнэт чулууны эдлэлийн арилжаа эрхлэх этгээд.

ХОЁР. Хяналт шалгалтын төрөл, ангилал

2.1 ҮМҮЧЭТХЭАЭ-д хийх хяналт шалгалт нь зайны, газар дээрх хяналт шалгалт гэсэн төрөлтэй байна.

2.2. Газар дээрх шалгалтыг үйл ажиллагааны хамрах цар хүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн гэж ангилна.

2.3. Иж бүрэн шалгалт нь Хорооны даргын баталсан газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичиг, гэрээний хэрэгжилт, холбогдох хууль тогтоомж, төрийн байгууллагаас баталсан болон дотоодын дүрэм, журам, заавар, шийдвэрүүдэд тулгуурлан үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

2.4. Хэсэгчилсэн шалгалт нь харилцагчдаас болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шүүмжлэлийн мөрөөр, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

ГУРАВ. Зайны хяналт, шалгалт

3.1. Зайны хяналт, шалгалтын зорилго нь ҮМҮЧЭТХЭАЭ-ээс ирүүлсэн тайлан мэдээ, мэдээлэл, зах зээлийн судалгаа болон холбогдох бусад мэдээлэл дээр үндэслэн тухайн салбарын болон тухайн этгээдийн болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад оршино.

3.2. Зайны хяналт, шалгалт хийх үйл ажиллагаа нь дараах дараалалтай байна:

3.2.1. Тухайн ҮМҮЧЭТХЭАЭ-ийн ирүүлбэл зохих тайлан, мэдээг хянаж, үндсэн үйл ажиллагааны болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.2. Тайлан, мэдээг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээ нь шаардлага хангаагүй бол тухайн ҮМҮЧЭТХЭАЭ-ийн эрх бүхий албан тушаалтанд шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

3.2.3. Тухайн ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх;

3.2.4. Шаардлагатай тохиолдолд ҮМҮЧЭТХЭАЭ-ээс нэмэлт тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг шаардах;

3.2.5. Шаардлагатай гэж үзвэл дараалсан хяналтыг хэрэгжүүлэх үүднээс ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх саналыг Хорооны холбогдох удирдлагад танилцуулна.

3.3. Хянан шалгагч нь ҮМҮЧЭТХЭАЭ-ээс ирүүлсэн тайлан мэдээг хянаж, эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд тайлангийн хариуг цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.

3.4. Хянан шалгагч нь хариуцсан ҮМҮЧЭТХЭАЭ-ээс нэгтгэлийн системд сарын мэдээг дараа сарын сүүлийн өдөр, эхний хагас жилийн мэдээллийг тухайн оны 8 дугаар сарын 30-ны өдөр, жилийн мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор баталгаажуулалт хийж, зайны болон газар дээрх хяналт шалгалтын нэгтгэл тайланг гаргана.

ДӨРӨВ. Газар дээрх хяналт, шалгалт

4.1. ҮМҮЧЭТХЭАЭ нь холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг тогтоох зорилгоор газар дээрх хяналт, шалгалтыг хийнэ.

4.2. Иж бүрэн хяналт шалгалтыг Хорооны даргын баталсан газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу, удирдамжийн хүрээнд хийнэ.

4.3. Хэсэгчилсэн шалгалтын удирдамжийг батлуулж, шалгалтад хамрагдах ҮМҮЧЭТХЭАЭ-д танилцуулснаар шалгалтыг эхлүүлнэ.

4.4. Хяналт шалгалтад хамрагдах ҮМҮЧЭТХЭАЭ-ээс дараах тайлан мэдээ, холбогдох баримт бичгүүдийг шаардана:

4.4.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт, компанийн дүрэм;

4.4.2., Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг зохицуулсан журам болон холбогдох бусад дүрэм, журмууд;

4.4.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, холбогдох баримт бичиг, удирдлага зохион байгуулалтын талаарх мэдээлэл;

4.4.4. Зайны болон газар дээрх хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, холбогдох баримт бичиг;

4.4.5. Санхүүгийн тайлан болон холбогдох тайлан мэдээ;

4.4.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон шийдвэр;

4.4.7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан дотоод хяналтын хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн хэрэгжилт;

4.4.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн талаарх баримт;

4.4.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан харилцагчийг таньж мэдэх үүргээ биелүүлсэн талаарх баримт бичиг;

4.4.10. Холбогдох бусад баримт бичиг.

4.5. Энэ журмын 1.4.1, 1.4.2-д заасан этгээд нь хувь хүн бол түүнд энэ журмын 4.4.1 дэх заалт хамаарахгүй байж болно.

4.6. Шалгалтын тайланд дараах мэдээллийг тусгана:

4.6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаарх дүгнэлт;

4.6.2. Тайлантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хариу шаардах, хариу шаардаагүй бол онцгойлон анхаарах асуудал.

4.7. Ажлын хэсэг шалгалтад хамрагдсан ҮМҮЧЭТХЭАЭ-ийн удирдлагад үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд өгсөн дүгнэлт болон шалгалтын акт, материалыг танилцуулна.

4.8. Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол тусгай зөвшөөрөл эзэмшигч тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

4.9. Шалгалтаар өгсөн дүгнэлтийг тухайн ҮМҮЧЭТХЭАЭ хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дүгнэлттэй танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

4.10. Хянан шалгагч нь ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хяналт, шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгана.

ТАВ. Мэдээ, тайлан

5.1. ҮМҮЧЭТХЭАЭ нь хуулийн этгээд бол Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, “Санхүүгийн тайлангийн А маягт”, “Санхүүгийн тайлангийн Б маягт”-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн эхний хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар болон албан бичгээр ирүүлнэ.

5.2. ҮМҮЧЭТХЭАЭ нь дараах мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ.

5.2.1. Үнэт металлын арилжааны мэдээ /Хавсралт 1/;

5.2.2. Үнэт чулууны арилжааны мэдээ /Хавсралт 2/;

5.2.3. Үнэт металлын эдлэлийн арилжааны мэдээ /Хавсралт 3/;

5.2.4. Үнэт чулууны эдлэлийн арилжааны мэдээ /Хавсралт 4/;

5.2.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний мэдээ /Хавсралт 5/;

5.3. Холбогдох бусад тайлан мэдээ.

ЗУРГАА. Хариуцлага

6.1. Шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмын дагуу холбогдох баримт, материалыг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

6.2. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 1 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр /хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ/											
								ОУЗЗҮнэ ам.доллар Алт: Мөнгө: Платина: Палладий: Бусад//иридий, родий, рутений, Осми /: МБ-ны ам.дол/төгрөгийн ханш: МБ-ны үнэт, металл худалдан авах ханш: Алт: Мөнгө:			
Худалдан авсан											
№	Гулдмайн дугаар	Бохир жин/грамм/	Алтны сорьц	Мөнгөний сорьц	Алтны цэвэр жин	Мөнгөний цэвэр жин	Платина цэвэр жин	Палладий	Бусад /иридий, родий, рутений, Осми/	Үнийн дүн	АМНАТ
1											
2											
3											
Нийт											
Худалдсан											
№	Гулдмайн дугаар	Бохир жин/грамм/	Алтны сорьц	Мөнгөний сорьц	Алтны цэвэр жин	Мөнгөний цэвэр жин	Платина цэвэр жин	Палладий цэвэр жин	Бусад /иридий, родий,	Үнийн дүн	АМНАТ

									рутений, Осми/		
1											
2											
3											
Нийт											

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 2 дугаар хавсралт

ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/CC/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр /хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ/							
							ОУЗЗҮнэ ам.доллар Доржпалам: Бадмаараг: Маргад эрдэнэ: Индранил: Сувд: МБ-ны ам.дол/төгрөгийн ханш: МБ-ны үнэт, металл худалдан авах ханш: Доржпалам: Бадмаараг: Маргад эрдэнэ: Индранил: Сувд:
Худалдан авсан							
№	Доржпалам цэвэр жин	Бадмаараг цэвэр жин	Маргад эрдэнэ цэвэр жин	Индранил цэвэр жин	Сувд цэвэр жин	Үнийн дүн	
1							
2							
3							

Нийт						
Худалдсан						
№	Доржпалам цэвэр жин	Бадмаараг цэвэр жин	Маргад эрдэнэ цэвэр жин	Индранил цэвэр жин	Сувд цэвэр жин	Үнийн дүн
1						
2						
3						
Нийт						

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 3 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛЫН ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр /хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ/										
Худалдан авсан										
№	Алтаар хийсэн эдлэл	Мөнгөөр хийсэн эдлэл	Платина хийсэн эдлэл	Палладий хийсэн эдлэл	Иридий хийсэн эдлэл	Родий хийсэн эдлэл	Рутений хийсэн эдлэл	Осми хийсэн эдлэл	Бусад	Үнийн дүн
1										
2										
3										
Нийт										
Худалдсан										

№	Алтаар хийсэн эдлэл	Мөнгөөр хийсэн эдлэл	Платина хийсэн эдлэл	Палладий хийсэн эдлэл	Иридий хийсэн эдлэл	Родий хийсэн эдлэл	Рутений хийсэн эдлэл	Осми хийсэн эдлэл	Бусад	Үнийн дүн	
1											
2											
3											
Нийт											

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 4 дүгээр хавсралт

ҮНЭТ ЧУЛУУНЫ ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр /хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ/											
Худалдан авсан											
№	Доржпаламаар хийсэн эдлэл	Бадмаарагаар хийсэн эдлэл	Маргад эрдэнэнээр хийсэн эдлэл	Индранилаар хийсэн эдлэл	Сувдаар хийсэн эдлэл	Нийт хэмжээ	Үнийн дүн				
1											
2											
3											
Нийт											
Худалдсан											

